



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/29

Булган

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 14/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Дашинчилэн суманд цэвэр усны даралтат цамхаг, инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: - Б.Анхбаяр

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: - М.Мөнхбат

Статистикийн хэлтсийн дарга

- Г.Гантулга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Иргэний төлөөлөл: - Х.Баясгалан

Булган сумын иргэн

Нарийн бичгийн дарга: - Г.Давааням

Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Б.Анхбаяр/-д үүрэг болгосугай.



**З.БАТЗОРИГ**